



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.13 № 3/414
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" ТӨААТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



“ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР” ТӨТӨААТҮГ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Үндэсний Аудитын газар
САГ-ын дарга Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас:261663
Цахим хаяг:

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260815
Цахим хаяг:

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг:
serjmyadagb@audit.gov.mn

“Их-над Аудит” ХХК
Байршил: БЗД 1-р хороо
ХХААХҮХолбоо 201 тоот
Утас: 99125283, 99077062
Цахим хуудас: ikhnayad-audit.mn
2016 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын тайлан

Хавсралт 2: Аудитын гэрчилгээний санал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18-р зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд ТЗҮЭГ-ын харъяа Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлангийн Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-ноос 2017 оны 2 дугаар сарын 10-ны хооронд хийхээр төлөвлөн “Их Наяд Аудит” ХХК-н аудитор Г.Дэмбэрэлсүрэн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 22-нд “Их Наяд Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Их-наяд Аудит” ХХК нь аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 20-наас 2017 оны 2 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 20-нд “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ нь төрийн байгууллагад мөрдөгдөж байгаа хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын хууль, Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ыг тухайн үеийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын сайд нарын Зөвлөлийн 1968 оны 7-р сарын 19-ны өдрийн 141 тоот захирамжаар байгуулсан байна. Энэ үйлдвэрийн хамт олон төр загийн хэрэгцээт бүтээгдэхүүнийг цаг хугацаанд хэвлэн гаргах нэр хүндтэй бөгөөд нэн хариуцлагатай ажлыг тасралтгүй 47 жил гүйцэтгэсээр иржээ. ЗГХЭГазар, яам, агентлагуудад ОУ-ын стандартад нийцсэн хэвлэлийн үйлчилгээ үзүүлэх, мөн төр засгийн хэрэгцээт бүтээгдэхүүнийг цаг хугацаанд нь орчин үеийн машин тоног төхөөрөмж хэвлэлийн аргаар түргэн шуурхай үйлчлэх үйлчилгээ явуулдаг.

ТЗҮЭГ-ын захирлын 2013 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 56 тоот тушаалаар “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын даргыг томилон ажиллуулж байна.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 31-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн программ нийцсэн байна.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-B-2/

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг бүртгэлийн Interactive компанийн Diamond санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайланд аудит гүйцэтгэхэд материаллагийн түвшин 213,8 сая төгрөгийн орлогын 1,0 % буюу 2,1 сая төгрөгөөр тогтоон аудитын сорилуудыг гүйцэтгэхэд материаллаг хэмжээний зөрчил гараагүй болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын удирдлага үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр ашгийн нэмэгдүүлэхэд хяналтыг сайжруулах үүднээс үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний орцын нормыг хянаж, үйлдвэрлэлийн дамжлага хооронд хүлээлцэх дэвтэр хөтлүүлж, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулснаар гологдол бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэхээ больсон байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ нь бие даасан орлогоороо зарлагаа нөхдөг, аж ахуйн тооцоотой үйлдвэр болон хөгжиж, үйлдвэрлэн гаргадаг бүтээгдэхүүний хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа байгууллага юм.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ удирдлага нь 2016 онд бараа үйлчилгээний орлого 338,5 сая төгрөг олохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 411,8 сая төгрөгийн орлого олж төлөвлөгөөгөө 21 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнээс урсгал зардалд 328,5 сая төгрөгийг төлөвлөснөөс 344,4 сая төгрөгийг зарцуулж, тайлант жилд 2,8 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан “Шилэн дансны тухай” хууль батлагдан 2016 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан ба “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ нь шилэн дансны зохион байгуулалтанд 2014 оны 03 дугаар сарын 03-наас орсон байна. 2016 оны шилэн дансны хуулийн дагуу 2016 оны 02 сарын 05-ны дотор Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн төлөвлөгөө ба тендер болон худалдан авах үйл ажиллагаанд 5,0 сая төгрөгөөс дээш гүйлгээ гараагүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 31 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудал гараагүй байна. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах алдаа гараагүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилтэй зүйл гараагүй байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2015 оны санхүүгийн тайланд “Их наяд Аудит” ХХК-наас хийсэн аудитаар зөвлөмж өгөөгүй.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ	*	*
1.1	Эргэлтийн хөрөнгө	*	*
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	78,598,461.47	108,998,507.21
1.1.2	Дансны авлага	5,515,200.00	6,070,220.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	54,107,778.06	63,732,910.24
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	138,221,439.53	178,801,637.45
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	438,829,261.17	429,620,503.08
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	438,829,261.17	429,620,503.08
1.3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН	577,050,700.70	608,422,140.53
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	1,165,255.43	2,229,477.58
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж олсон орлого	4,389,258.03	9,211,361.93
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,554,513.46	11,440,839.51
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			

2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	5,554,513.46	11,440,839.51
2.3	2. Эзэмшигчийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	47,942,966.07	47,942,966.07
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,040,957.77	19,040,957.77
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	319,150,000.00	319,150,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	185,362,263.40	210,847,377.18
2.3.11	Эздийн өмчийн дүн	571,496,187.24	596,981,301.02
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	577,050,700.70	608,422,140.53

-
-

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	340,691,818.00	411,822,760.00
2	Борлуулалтын өртөг	257,443,254.98	302,268,307.87
3	Нийт ашиг /алдагдал/	83,248,563.02	109,554,452.13
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	2,058,648.54	2,522,265.68
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	113,848.53	503,557.50
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	33,328,282.92	42,121,238.61
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	46,629,227.85	42,142,243.52
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,463,549.32	28,316,793.18
19	Орлогын татварын зардал	534,970.08	2,831,679.40
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,928,579.24	25,485,113.78
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	4,928,579.24	25,485,113.78
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	4,928,579.24	25,485,113.78
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12-р сарын 31

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12 сарын 31 үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77		319,150,000.00	185,362,263.40	571,496,187.24
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						-
3	Залруулсан үлдэгдэл						-
4	Тайлант үеийн цэвэр ашиг					25,485,113.78	25,485,113.78
5	Бусад дэлгэрэнгүй орлого						-
6	Өмчид гарсан өөрчлөлт						-
7	Зарласан ногдол ашиг						-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						-
9	2016 оны 12 сарын 31 үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77	-	319,150,000.00	210,847,377.18	596,981,301.02

-

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	400,097,659.30	464,748,291.50
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	400,097,659.30	464,244,734.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		503,557.50
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	379,371,573.99	435,412,511.44
	Ажилчдад төлсөн	116,642,262.64	133,631,106.30
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	31,705,485.66	34,954,839.18
	Бараа материал худалдан авахад төлсөн	155,459,153.73	182,454,749.22
	Ашиглалтын зардалд төлсөн	360,000.00	0.00
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		5,295,086.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	40,550,904.11	48,861,687.22
	Бусад мөнгөн зарлага	34,653,767.85	30,215,043.52
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,726,085.31	29,335,780.06
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
	Мөнгөн орлогын дүн (+)	2,058,648.54	2,522,265.68
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны оуцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	2,058,648.54	2,522,265.68
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,759,925.00	1,458,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	9,759,925.00	1,458,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(7,701,276.46)	1,064,265.68
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Ханшийн зөрүү		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	13,024,808.85	30,400,045.74
	Валютын ханшийн зөрүү		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,573,652.62	78,598,461.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	78,598,461.47	108,998,507.21